



# History of the XX Century Mongolia

1921 REVOLUTION: 6. MONGOLIA & SOCIALISM

## LECTURE 10

LECTURER: PROF. OTGONJARGAL SODNOMDARJAA

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

# XX зууны Монголын Түүх

1921 ОНЫ ХУВЬСГАЛ: 6. МОНГОЛ БА СОЦИАЛИЗМ

## ЛЕКЦ 10

ПРОФ.ОТГОНЖАРГАЛ СОДНОМДАРЖАА

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## Лекцийн агуулга

Энэ лекцээр Монголд социализм хэрхэн орж ирсэн түүхийг мэдэхийн зэрэгцээ Диалектикаар дүгнэвэл монголын хөгжлийн гол субстанц болсон сэтгэлгээний эрх чөлөө хаагдах эхлэл энэ цаг үеэс эхэлснийг ойлгож авна

МАН-ыг байгуулах хурлыг  
яаралтай нээж намын  
мөрийн хөтөлбөр зэргийг  
тогтоон явуулахыг урьдал  
болгохыг Коминтернээс  
чухалчилсан учир  
Коминтерний төлөөлөгч  
Борисов, Лосол,  
Шагдаржав, Цэдэн-Иш  
нарын бие Намын  
анхдугаар хурлыг  
хуралдуулах явдлыг  
яаравчлан бэлтгэхээр  
Троицкосавск хотын газраа  
хүрч ирэв



[This Photo](#) by Unknown Author is licensed under [CC BY-SA](#)

Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд номонд МАН-ын анхны гишүүн Баламсуу дурсагдаа

“ ... Барон Унгерн Нийслэл Хүрээг эзлэн авсан учир ... уг хувьсгалын ажлыг эхлэн явуулна хэмээхэд аливаагаас хоцрогдох, хожигдох нь үлэмжхэн болж... намын анхдугаар хурлыг Хиагт орчмын нөхдийг яаравчлан зарлан хуралдуулж... маш хурдавчлан гүйцэтгэн явуулбаас зохих болсон тул цөмөөр Гэгээтийн дацангаас Троицкосавск хотын газраа одож... арваннэгдүгээр оны 3 сарын 1 бөгөөд цагаан сарын 22-ны өдөр Намын анхдугаар хурлыг ... нээжээ” гэсэн байдаг



<https://www.sonin.mn>

Хувьсгалчдын зөвөлгөөн.Троицкосавск

1921 оны 3-р сарын 1-нд Дээд Шивээ хотноо монголын төлөөлөгчдийг ийнхүү яаралтай дуудан ирүүлж МАН-ыг байгуулав.

Энэхүү хурал дээр монголын төлөөлөгчдийн хэлсэн үгэнд Монгол орноо “Тэгш журамт, баян хүчирхэг улс болгохын тулд эрдэм боловсролыг эрчимтэй хөгжүүлэх, гадаад олон улстай эрх тэгш харилцах, ёстой” гэсэн утга санаа нэг биш удаа илэрхийлэгдсэн байдаг.



[This Photo](#) by Unknown Author is licensed under [CC BY-SA](#)

С.Данзан

Монгол улсад Богд хаант засгийн газар 1921 оны 2 сарын 22-ны өдөр албан ёсоор байгуулагдаж хөрш зэргэлдээ Хятад, Орос улсад тусгаар тогтнолоо зарласан байдлыг үл харгалзан 24 хоногийн дараа Монголын Түр Засгийн газар гэгч Орос улсад байгуулагдав.



<https://mongoltoli.mn>

ТЗГ-ын анхны дарга Д.Чагдаржав

Монгол улсад Улааны аюул бодитой нүүрэлсэн явдал байв.

Орос улсад байгуулагдсан засгийн газрыг зөвтгөхийн тулд үзэл суртлын арга хэмжээг хүчтэй явуулж байв.

“Богд гэгээн ба толгойлогч феодалууд дахин улс орныхоо сонирхолыг худалдан японы империализмын тагнуулын талд оров” “Богд хаан ба түүний засгийн газар бол тоглоомын этгээдүүд юм” “Цагаантнууд Богд гэгээний эхнэрийг буудан алав” гэх мэт ухуулгыг хязгаар нутгийн мэдээлэл муутай ард түмний дунд цацах болжээ.



<https://mn.wikipedia.org>

Богд хаант засгийн газрыг  
“Унгерны тоглоомын  
засгийн газар” хэмээн  
сурталчилсаар байв.

Монголын засгийн газар  
түүхэнд мартагдашгүй  
гавьяа байгуулсан юм.


Хүрээнээс хятадын их  
цэргийг Монголын нутаг  
дэвсгэрээс бүрэн хөөн  
зайлуулсан түүхтэй.



<http://www.touristinfocenter.mn>



Монголын засгийн газар Их Орос Улсын  
Засгийн Газрын төлөөлөгч нарыг Нийслэл  
Хүрээнээ ирж дипломат харилцаа тогтоох  
хүсэлт илгээжээ




Монголын Засгийн газар улс орондоо гадны цэргийн хүчийг оруулахгүй байх талаар олон арга сүвэгчилсэн боловч бүтсэнгүй.

1921 оны 3-р сарын 18-нд Хиагтыг чөлөөлж анхны ялалтаа байгуулсан Улаан армийн анги нэгтгэл, монгол цэргийн хамт 7-р сарын 6-7-нд Нийслэл хүрээнд орж ирэв.

Богд хаант засгийн газрын биет төлөөлөгчид  
хадаг барин угтав.



<https://mn.wikipedia.org>



Засаг төрийг шинээр эмхлэн байгуулах Оросын саналыг Монголын тал эсэргүүцэлгүй хүлээн авснаар 1921 оны 7-р сарын 10-нд 2-р сарын 22-нд байгуулагдсан Монголын засгийн газрыг татан буулгаж, яамдын тамгыг шинэ засгийн газарт шилжүүлэн өгчээ.

# References

1. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд, Дашням Г, “Соёмбо принтинг”, 2004
2. Монголын мартагдсан түүх Богд хаант засгийн газар (1911-1921), Тачибана М, “МН Технологи” хэвлэх үйлдвэр, 2011
3. Барон Унгерн, Урга и Алтан-Булак, Першин Д.П, Самара Издательский дом “Агни”, 1999

*АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА*